



МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛИЙН МЭДЭГДЭЛ

Мөнгөний бодлогын хэрэгслийг боловсронгуй болгох тухай

Дугаар: 2013/02

Огноо: 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдөр

Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны 2 дугаар сарын 27-ны өдөр хуралдаж, нэг талаас дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, нөгөө талаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүний коридорыг шинээр нэвтрүүлэхээр шийдвэрлэв.

Хүүний коридорыг нэвтрүүлж, мөнгөний бодлогын хэрэгслүүдийг боловсронгуй болгосноор богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Дээрх шийдвэрийг гаргаснаар мөнгөний бодлогын хэрэгслийн хүүний бүтэц бүрэн шинэчлэгдэх төдийгүй овернайт репо санхүүжилт, овернайт хадгаламж гэсэн шинэ хэрэгслүүд бий болно.

Шинээр нэвтрүүлэх хүүний коридорын өргөн нь Монголбанкны бодлогын хүүнээс +/-2 нэгж хувь байх бөгөөд коридорын дээд хязгаарыг овернайт репо санхүүжилтийн хүү (бодлогын хүү + 2 нэгж хувь), харин доод хязгаарыг овернайт хадгаламжийн хүү (бодлогын хүү - 2 нэгж хувь) тус тус тодорхойлно.

Бодлогын уг арга хэмжээг авснаар банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах суурь нөхцөл бүрдэхийн зэрэгцээ Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурч, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлнө.

МӨНГӨНИЙ БОДЛОГЫН ЗӨВЛӨЛ